



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/99

Булган сум

“Густокек” ХХК-тай гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 сарын 05-ний өдрийн XIX/08 дугаар хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолын 3 дугаар хавсралтын 2.14 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Баяннуур сумын соёлын төвийн барилгын их засварын ажлын үлдэгдэл санхүүжилт болох 15,500,000 (арван таван сая таван зуун мянга) төгрөгөөр “Густокек” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Үлдэгдэл санхүүжилтэй холбоотой бичиг баримтыг хүлээлгэн өгөхийг “Густокек” ХХК-ийн захирал (Т.Сэргэлэн)-д үүрэг болгосугай.

3. Булган аймгийн Баяннуур сумын соёлын төвийн барилгын их засварын ажлын үлдэгдэл ажлын бичиг баримтад хяналт тавьж, холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4. Булган аймгийн Баяннуур сумын соёлын төвийн барилгын их засварын ажлын үлдэгдэл санхүүжилтийг Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА БАРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010142